

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	7
3. Менежментийн захидал.....	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.02.27 № 06/612  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Биологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Биологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Биологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Я.Адъяа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн Нягтлан бодох бүртгэлдээ ашиглаж буй “Acolous” програм хангамжийн хөгжүүлэлтийг сайжруулан санхүү, эдийн засгийн орчинд ашиглагдаж байгаа бусад системтэй харилцан уялдуулах, мэдээлэл солилцох боломжтой болгох зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд УАГ-тай байгуулсан гурвалсан гэрээг үндэслэн “Мэдээлэл-Аудит” ХХК аудит хийлээ.

Биологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 11-нээс 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мэдээлэл-Аудит ХХК-ийн захирал Д.Товуудорж, аудитор Д.Туяа, шинжээч С.Наранцэцэг, Чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Биологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Мэдээлэл-Аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/16 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Биологийн хүрээлэн нь Монгол орны биологийн нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах, сэргээн үржүүлэх, биологи үндэслэл боловсруулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” 27 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газар, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Сайдын 2015 оны 09 сарын 02-ны өдрийн А/337 дугаар тушаалд ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Монгол орны амьтны аймгийн биологи, экологи онцлог, антропогенийн болон уур амьсгалын өөрчлөлт амьтны аймагт нөлөөлөх зүй тогтлыг судлан илрүүлж, амьд байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдал, биологийн олон янз байдлыг хадгалах, нөөц баялгийг хамгаалах, тогтвортой ашиглах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах;
2. Монгол орны амьтны гарал үүслийг тогтоох, генийн сан бүрдүүлэх, сэргээн үржүүлэх генетик үндэслэл боловсруулах, эмийн болон ганд тэсвэртэй ургамлыг биотехнологийн аргаар үржүүлэх хоёрдогч метаболитын судалгаа хийх, хавдрын эсийг дарангуйлах ургамлын гаралтай биологийн идэвхт бодисыг судлах, хавдрын молекул механизм, шалтгааныг тогтоох, оношилгооны цомог гарган авах, хувиргасан амьд организмыг илрүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол улсын засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаал цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-ыг мөрдөн ажиллаж байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Биологийн хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Биологийн хүрээлэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Биологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Биологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд аудитын 5 чиглэлд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 873,553.1 мянган төгрөгөөс тооцон 17,471.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Биологийн хүрээлэн нь Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор 2019 оны 9 дүгээр сараас эхлэн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт орсонтой холбогдон 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо дансад үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	0.0	61,524.9	61,524.9
Үндсэн хөрөнгө	0.0	2,096,049.5	2,096,049.5
Үндсэн хөрөнгийн элэгдэл		-15,015.2	-15,015.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>0.0</b>	<b>2,142,559.2</b>	<b>2,142,559.2</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	0.0	2,634,264.0	2,634,264.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>0.0</b>	<b>2,142,559.2</b>	<b>2,142,559.2</b>

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн нь 2015 онд Засгийн газрын 27 дугаар тогтоолоор 158 хүний орон тоотой байгуулагдсан. Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор Биологийн хүрээлэн 95 орон тоотой 2019 оны 09 дүгээр сарын 01-ээс эхлэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эхлэлтийн балансаар 71,934.9 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч 46,880.3 мянган төгрөгийн бараа материалыг орлогод бүртгэн 57,290.3 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна. Тайлант хугацааны эцэст 61,524.9 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл байна.

Тус хүрээлэн нь Засгийн газрын 2019 оны 328 тогтоолыг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэл болгон хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн, эхлэлтийн балансаар 2,067,934.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үлдэх өртгөөр нь авч эрдэм шинжилгээний зардлаас санхүүжүүлэн 24,774.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, урсгал үйл ажиллагааны санхүүжилтээс 3,350.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч нийт 28,124.2 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгө нэмэгдсэн. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд 15,015.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо 2,634,264.0 мянган төгрөг, тайлант хугацааны үр дүн 2,020,164.3 мянган төгрөг байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх урсгал үйл ажиллагааны зардалд зориулан 525,867.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Улсын төсвөөс 524,077.1 мянган төгрөгийн санхүүжилт авч үндсэн үйл ажиллагаанаас 7,245.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 525,735.6 мянган төгрөг зарцуулж 5,586.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 222,534.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс тогтмол зардалд 5,000.0, хангамж бараа материалын зардалд 15,662.6, эд хогшил худалдан авахад 16,660.0, томилолт зочны зардалд 10,000.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 175,212.3, нийт 222,534.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж 1 эрсдэл тодорхойлж, нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар 2015 оноос эхлэн Нягтлан бодох бүртгэлдээ ашиглаж буй "Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн "Acolous" програм хангамж нь СТАУС програм болон санхүү, эдийн засгийн орчинд ашиглагдаж байгаа бусад системтэй харилцан уялдаагүй, мэдээлэл солилцох боломжгүй байгаад зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Биологийн хүрээлэн дараагийн аудитаар анхаарал татахуйц чухал асуудал гараагүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Биологийн хүрээлэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээлэл байршуулахаас 132 мэдээллийг хугацаанд нь, 17 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Биологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Биологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж

3.1.1 Илрүүлэлт: 2015 оноос эхлэн Нягтлан бодох бүртгэлдээ ашиглаж буй "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" програм хангамж нь СТАУС програм болон санхүү, эдийн засгийн орчинд ашиглагдаж байгаа бусад системтэй харилцан уялдаагүй, мэдээлэл солилцох боломжгүй байна. Энэ нь "эрх ба үүрэг", "үнэн зөв" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалыг зөрчсөн байна.

#### 3.1.2 Эрсдэл:

- НББ-ийн тухай хууль зөрчигдөх
- Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаал зөрчигдөх
- Мэдээлэл солилцох боломжгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлдээ санхүү, эдийн засгийн орчинд ашиглагдаж байгаа бусад системтэй харилцан уялдаах боломжтой санхүүгийн програм хангамжтай болох

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" програмыг сайжруулалт хийлгэх шаардлагатай байгаа тул цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>61 524 883,00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		<b>61 524 883,00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		<b>61 524 883,00</b>
35410	Бичиг хэргийн материал		1 300 178,00
35420	Аж ахуйн материал		17 939 980,00
35440	Түлш, шатах тослох материал		757 000,00
35470	Бусад хангамжийн материал		41 527 725,00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>2 081 034 331,10</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		<b>2 081 034 331,10</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		<b>1 547 977 364,42</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц		1 277 082 763,09
39202	Хуримтлагдсан элэгдэл		-11 838 624,96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		246 335 986,75
39206	Хуримтлагдсан элэгдэл		-1 397 590,67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		10 558 508,33
39208	Хуримтлагдсан элэгдэл		-240 283,64
39214	Бусад үндсэн хөрөнгө		26 454 500,00
39215	Хуримтлагдсан элэгдэл		-1 469 694,48
39217	Ном		2 491 800,00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		<b>533 056 966,68</b>
39301	Програм хангамж		1 035 650,00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-69 043,32
39303	Бусад биет бус хөрөнгө		532 090 360,00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>2 142 559 214,10</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>2 142 559 214,10</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>2 142 559 214,10</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		2 634 264 011,92
51101	Өмч: - төрийн		2 634 264 011,92
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		<b>-491 704 797,82</b>
51210	Өмнөх үеийн үр дүн		-2 511 869 148,35
51220	Тайлант үеийн үр дүн		2 020 164 350,53
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>2 142 559 214,10</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2 575 451 787,00</b>	<b>2 893 717 410,17</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>12 949 318,00</b>	<b>2 147 105 381,17</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	12 949 318,00	2 147 105 381,17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12 949 318,00	2 147 105 381,17
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6 300 000,00	1 290 000,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6 649 318,00	5 955 036,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	2 139 860 345,17
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2 546 813 134,00</b>	<b>746 612 029,00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1 817 515 200,00	524 077 100,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 817 515 200,00	524 077 100,00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>729 297 934,00</b>	<b>222 534 929,00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	66 377 784,00	17 297 800,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	583 963 000,00	121 137 028,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	78 957 150,00	84 100 101,00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	<b>15 689 335,00</b>	-
	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	15 689 335,00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1 996 561 425,98</b>	<b>873 553 059,64</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1 996 561 425,98</b>	<b>873 553 059,64</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1 993 963 925,98	862 669 523,64
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1 419 314 988,12</b>	<b>344 194 613,57</b>
210101	Үндсэн цалин	1 419 314 988,12	245 989 013,57
210102	Нэмэгдэл	-	69 299 400,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	28 906 200,00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>168 716 011,88</b>	<b>38 927 519,00</b>
210201	Тэтгэврийн даатгал	115 217 422,88	26 264 027,00
210202	Тэтгэмжийн даатгал	14 097 626,00	2 892 579,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10 992 021,00	2 462 544,00
210204	Ажилгүйдлийн даатгал	2 559 077,00	675 477,00
210205	Эрүүл мэндийн даатгал	25 849 865,00	6 632 892,00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45 267 600,00</b>	<b>18 390 451,00</b>
210301	Гэрэл, цахилгаан	28 021 140,00	13 988 045,00
210302	Түлш, халаалт	15 052 640,00	3 461 678,00
210303	Цэвэр, бохир ус	2 193 820,00	940 728,00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21 817 348,00</b>	<b>32 490 439,00</b>
210401	Бичиг хэрэг	2 502 020,00	2 165 300,00
210402	Тээвэр, шатахуун	2 240 000,00	9 600 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 893 398,00	331 400,00
210404	Ном, хэвлэл	10 566 070,00	12 709 800,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3 120 860,00	6 610 939,00
	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1 495 000,00	1 073 000,00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>456 000,00</b>	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	456 000,00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3 966 100,00	-
210604	Урсгал засвар	3 966 100,00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10 500 000,00</b>	<b>14 882 200,00</b>
210702	Дотоод албан томилолт	10 500 000,00	14 882 200,00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>250 783 899,00</b>	<b>395 854 664,00</b>

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	248 210 899,00	391 854 664,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2 000 000,00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210 000,00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	363 000,00	-
210807	Газрын төлбөр	-	4 000 000,00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>73 141 978,98</b>	<b>17 929 637,07</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2 700 000,00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2 914 400,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70 441 978,98	15 015 237,07
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2 597 500,00</b>	<b>10 883 536,00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2 597 500,00</b>	<b>5 297 000,00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2 597 500,00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5 297 000,00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>5 586 536,00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5 586 536,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>578 890 361,02</b>	<b>2 020 164 350,53</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2 700 000,00</b>	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	2 700 000,00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	2 700 000,00	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>581 590 361,02</b>	<b>2 020 164 350,53</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2 602 410 682,00</b>	<b>753 857 065,00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>25 108 738,00</b>	<b>7 245 036,00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	25 108 738,00	7 245 036,00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	25 108 738,00	7 245 036,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6 300 000,00	1 290 000,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18 808 738,00	5 955 036,00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2 577 301 944,00</b>	<b>746 612 029,00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1 817 515 200,00	524 077 100,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 817 515 200,00	524 077 100,00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>729 297 934,00</b>	<b>222 534 929,00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	66 377 784,00	17 297 800,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	583 963 000,00	121 137 028,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	78 957 150,00	84 100 101,00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	30 488 810,00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	30 488 810,00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2 396 930 712,00</b>	<b>725 732 865,00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2 396 930 712,00</b>	<b>725 732 865,00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2 394 333 212,00</b>	<b>714 849 329,00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1 420 102 746,00	389 025 800,00
210101	Үндсэн цалин	1 293 716 246,00	307 188 000,00
210102	Нэмэгдэл	60 780 600,00	57 748 900,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57 812 800,00	24 088 900,00
210104	Урамшуулал	7 793 100,00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	169 043 300,00	49 094 100,00
210201	Тэтгэврийн даатгал	114 642 500,00	27 302 609,00
210202	Тэтгэмжийн даатгал	13 841 000,00	6 644 800,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10 880 200,00	5 315 800,00
210204	Ажилгүйдлийн даатгал	2 479 200,00	1 329 000,00
210205	Эрүүл мэндийн даатгал	27 200 400,00	8 501 891,00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	45 267 600,00	21 932 200,00
210301	Гэрэл, цахилгаан	28 021 140,00	17 529 794,00
210302	Түлш, халаалт	15 052 640,00	3 461 678,00
210303	Цэвэр, бохир ус	2 193 820,00	940 728,00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	36 958 000,00	30 649 870,00
210401	Бичиг хэрэг	2 300 020,00	1 673 100,00
210402	Тээвэр, шатахуун	1 140 000,00	8 960 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 893 398,00	331 400,00
210404	Ном, хэвлэл	21 747 400,00	12 709 800,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1 495 000,00	1 073 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8 382 182,00	5 902 570,00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	41 942 700,00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	946 700,00	-

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210604	Урсгал засвар	40 996 000,00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>44 464 200,00</b>	<b>14 882 200,00</b>
210702	Дотоод албан томилолт	44 464 200,00	14 882 200,00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>628 404 666,00</b>	<b>206 350 759,00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	624 859 666,00	201 386 759,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2 000 000,00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45 000,00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1 500 000,00	964 000,00
210807	Газрын төлбөр		4 000 000,00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8 150 000,00</b>	<b>2 914 400,00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8 000 000,00	2 914 400,00
	Бараа үйлчилгээний бусад зардал	150 000,00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2 597 500,00</b>	<b>10 883 536,00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2 597 500,00</b>	<b>5 297 000,00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2 597 500,00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5 297 000,00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>5 586 536,00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5 586 536,00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>205 479 970,00</b>	<b>28 124 200,00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>126 940 370,00</b>	<b>28 124 200,00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>126 940 370,00</b>	<b>28 124 200,00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>126 940 370,00</b>	<b>28 124 200,00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	126 940 370,00	28 124 200,00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-126 940 370,00</b>	<b>-28 124 200,00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>78 539 600,00</b>	<b>-</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>00,00</b>	<b>00,00</b>	<b>00,00</b>	<b>00,00</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00,00</b>	<b>00,00</b>	<b>00,00</b>	<b>00,00</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	00,00	00,00
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00,00</b>	<b>00,00</b>	<b>00,00</b>	<b>00,00</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2 634 264 011,92	-	-2 511 869 148,35	<b>122 394 863,57</b>
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2 634 264 011,92</b>	<b>00,00</b>	<b>-2 511 869 148,35</b>	<b>122 394 863,57</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	<b>00,00</b>
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	2 020 164 350,53	<b>2 020 164 350,53</b>
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2 634 264 011,92</b>	<b>00,00</b>	<b>-491 704 797,82</b>	<b>2 142 559 214,10</b>

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	99,9
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>525 867 100,00</b>	<b>525 735 600,00</b>	<b>131 500,00</b>	99,9
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>525 867 100,00</b>	<b>525 735 600,00</b>	131 500,00	99,9
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	520 570 100,00	520 438 600,00	131 500,00	99,9
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>389 025 800,00</b>	<b>389 025 800,00</b>	-	100
210101	Үндсэн цалин	307 188 000,00	307 188 000,00	-	100
210102	Нэмэгдэл	57 748 900,00	57 748 900,00	-	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24 088 900,00	24 088 900,00	-	100
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>49 094 100,00</b>	<b>49 094 100,00</b>	-	100
210201	Тэтгэврийн даатгал	22 514 200,00	27 302 609,00	-4 788 409,00	-
210202	Тэтгэмжийн даатгал	6 644 800,00	6 644 800,00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	5 315 800,00	5 315 800,00	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	1 329 000,00	1 329 000,00	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	13 290 300,00	8 501 891,00	4 788 409,00	64
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16 932 200,00</b>	<b>16 932 200,00</b>	-	100
210301	Гэрэл, цахилгаан	4 095 700,00	12 529 794,00	-8 434 094,00	-
210302	Түлш, халаалт	8 616 500,00	3 461 678,00	5 154 822,00	40
210303	Цэвэр, бохир ус	4 220 000,00	940 728,00	3 279 272,00	22
210304	Байрны түрээс	-	-	-	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15 086 400,00</b>	<b>14 987 300,00</b>	99 100,00	99
210401	Бичиг хэрэг	202 100,00	473 100,00	-271 000,00	-
210402	Тээвэр, шатахуун	400 000,00	400 000,00	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3 109 300,00	331 400,00	2 777 900,00	11
210404	Ном, хэвлэл	10 400 000,00	12 709 800,00	-2 309 800,00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	975 000,00	1 073 000,00	-98 000,00	110
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4 650 100,00</b>	<b>4 650 100,00</b>	-	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	4 650 100,00	4 650 100,00	-	100
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4 882 200,00</b>	<b>4 882 200,00</b>	-	100
210702	Дотоод албан томилолт	4 882 200,00	4 882 200,00	-	100
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37 984 900,00</b>	<b>37 952 500,00</b>	32 400,00	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32 988 500,00	32 988 500,00	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32 400,00	-	32 400,00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	964 000,00	964 000,00	-	100
210807	Газрын төлбөр	4 000 000,00	4 000 000,00	-	100
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2 914 400,00</b>	<b>2 914 400,00</b>	-	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2 914 400,00	2 914 400,00	-	100
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5 297 000,00</b>	<b>5 297 000,00</b>	-	100



Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5 297 000,00	5 297 000,00	-	100
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5 297 000,00	5 297 000,00	-	100
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>525 867 100,00</b>	<b>531 322 136,00</b>	<b>-5 455 036,00</b>	101
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>524 077 100,00</b>	<b>524 077 100,00</b>	-	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	524 077 100,00	524 077 100,00	-	100
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1 790 000,00</b>	<b>7 245 036,00</b>	-5 455 036,00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1 290 000,00	1 290 000,00	-	100
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500 000,00	5 955 036,00	-5 455 036,00	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>95</b>	<b>95</b>	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	83	83	-	100
620003	Үйлчлэх ажилтан	11	11	-	100

**4.6 Аудит хийгсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>222 534 929,00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>222 534 929,00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>222 534 929,00</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>5 000 000,00</b>
210301	Гэрэл, цахилгаан		5 000 000,00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>15 662 570,00</b>
210401	Бичиг хэрэг		1 200 000,00
210402	Тээвэр, шатахуун		8 560 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5 902 570,00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>16 660 000,00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		16 660 000,00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>10 000 000,00</b>
210702	Дотоод албан томилолт		10 000 000,00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>175 212 359,00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		175 212 359,00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>21 373 100,00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		21 373 100,00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>41 963 756,00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>41 963 756,00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		41 963 756,00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>222 534 929,00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>222 534 929,00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		17 297 800,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		121 137 028,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		84 100 101,00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>		
620001	Удирдах ажилтан		
620002	Гүйцэтгэх ажилтан		
620003	Үйлчлэх ажилтан		

**5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>Биологийн хүрээлэн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
<b>2020.02.18</b>			САГ-2020/192/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Биологийн хүрээлэн		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2015 оноос эхлэн Нягтлан бодох бүртгэлдээ ашиглаж буй "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" програм хангамж нь СТАУС програм болон санхүү, эдийн засгийн орчинд ашиглагдаж байгаа бусад системтэй харилцан уялдаагүй, мэдээлэл солилцох боломжгүй байна.	0.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Ё.Гангамөрөн
	<b>Дүн</b>	<b>0.0</b>			

